

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж:

1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Хэдий үед хэрэглэж байсан зэвсгийг шинэ чулуун зэвсэг гэдэг вэ? /1 оноо/
 A. 800 000-100 000 жилийн үед
 B. 100 000-40 000 жилийн үед
 C. 40 000-15 000 жилийн үед
 D. 15 000-8000 жилийн үед
 E. 8000-3000 жилийн үед
2. Мөстлөгийн үеэс хүний амьдрал үйл ажиллагаанд ямар өөрчлөлт орсон бэ? /1 оноо/
 A. Ангийн арьсан нөмрөг хэрэглэх болж хувцасны үүсэл тавигдсан
 B. Агуйн зэрэгцээ овоохой барьж суудаг болов.
 C. Галыг гарган авч хэрэглэдэг боллоо.
 D. Дээрх бүгд хариулт хамаарна.
 E. А ба В хариулт хамаарна.
3. Хүрэл болон төмөр зэвсэгтний эхэн үеийн аймгийн үндсэн шинжийг өгүүлэхдээ түүнд үл хамаарах шинжийг дурьдсан байна уу? /1 оноо/
 A. Өөр өөрийн нэртэй
 B. Тогтсон газар нутагтай
 C. Нэгэн хэл аялгуугаар ярьдаг
 D. Хэд хэдэн аймгууд цэргийн хүчирхэг удирдагчийн захиргаанд нэгдсэн
 E. Энд тийм зүйлийн тухай өгүүлээгүй байна.
4. Монгол нутгаас хичнээн тооны буган хөшөө олддоод байна вэ? /1 оноо/
 A. 700 орчим
 B. 550 орчим
 C. 400 орчим
 D. 300 орчим
 E. 200 орчим
5. НТӨ 214 онд Хятадын 100 000 цэрэг Хүннүгийн нутгийн өмнөд хэсэг Ордосыг эзлэн авчээ. Энэ үйл явдал хэддүгээр зууны хэддүгээр хагаст болсон бэ? /1 оноо/
 A. НТӨ I зууны I хагас
 B. НТӨ II зууны I хагас
 C. НТӨ II зууны II хагас
 D. НТӨ III зууны I хагас
 E. НТӨ III зууны II хагас
6. Жужан улс 555 онд задран Түрэгүүдэд эзлэгдэх болсны гол шалтгааны талаар ташаа зүйл өгүүлсэн байна уу? /2 оноо/
 A. Жужаны хаад авилгад автан, биеэ тоож, бодит байдлыг ойлгох чадваргүй болсон
 B. Алтайн Түрэгүүдийн тусгаар тогтнолын төлөө тэмцэл хөдөлгөөн
 C. Язгууртан сурвалжтнуудын эв нэгдэлгүй агаад өөр хоорондын тэмцэл
 D. Уйгар улсын довтолгоон
 E. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.
7. 552 онд Ашина овгийн зонхилгогч хэн нь Түрэгийн хаант улсыг байгуулсан бэ? /1 оноо/
 A. Культегин
 B. Тоньюкук
 C. Моюнчур
 D. Буман
 E. Пэйло
8. Дор дурьдсан оны цолын аль нь Монголын эртний улсуудын үеийн түүхэнд хамаарах вэ? /1 оноо/
 A. Бурхны шашны сургаал ёсоор Ашид амгалан, Машид тайван, Энх түвшин гэх мэт оны цол
 B. Олноо өргөгдсөн гэсэн оны цол
 C. Монгол улсын гэсэн оны цол
 D. Энх-Амгалан, Найралт төв, Тэнгэрийн тэтгэсэн гэх мэт оны цол
 E. Энд ийм зүйл байхгүй байна.
9. Аль нь билгийн тоолол хэмээх ойлголтыг тодорхойлох гол үндэс болдог вэ? /1 оноо/
 A. Сарны хөдөлгөөн
 B. Нарны хөдөлгөөн
 C. Манай гарагийн хөдөлгөөн
 D. А ба С хариулт хамаарна
 E. А ба В хариулт хамаарна
10. “Монгол” хэмээх нэрийн гарал үүслийн талаарх таамаглалуудыг нэрлэхдээ хамааралгүй зүйл дурьдсан байна уу? /1 оноо/
 A. Газар усны нэрнээс үүсэлтэй.
 B. Эртний овог, аймгийн нэрнээс үүсэлтэй.
 C. Овог, аймгийн толгойлогчийн нэрнээс үүсэлтэй.
 D. Тохиолдлын шинжтэй үүссэн.
 E. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.
11. Домогт өгүүлснээр Алангоо хатнаас тэнгэрийн гэрлийн үйлчлэлээр төрсөн Бугу Хатаги, Бугути Салжи, Бодончар нарын удмаас үүссэн салбар Монгол аймгийн нэр аль нь вэ? /1 оноо/
 A. Дарлиган
 B. Нирун
 C. Урианхайд
 D. Хонгирад
 E. Элжигэн
12. XI-XII зууны үед Татар аймгийн нутаг хаагуур байсан бэ? /1 оноо/
 A. Заг Байдраг, Сэлэнгэ Туул, Элсэн говийн хооронд
 B. Орхоны адаг, Сэлэнгийн дунд биеэр
 C. Хөлөн Буйр нуураар төвлөрч байв.
 D. Хэрлэн, Онон, Туул голын сав газраар
 E. Орхон голоос Эрчис мөрөн, Хангайн нуруунаас Алтайн чанад хүрч байв.

13. Хамаг Монголын ханлигийн хүчирхэгжихэд үл хамаарах хүчин зүйлүүд өгүүлсэн байна уу? /2 оноо/
 А. Хамаг Монголын хангуудын зөв мэргэн бодлого
 В. Хамаг Монгол дотооддоо эв нэгдэлтэй байсан.
 С. Бусад аймгууд тухайлбал Найман, Татар, Мэргэдийн ханлиг дотооддоо зөрчилтэй байсан.
 D. Хэрэгдтэй найрсаг харилцаатай байж, бие биеэ дэмжих болсон.
 E. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.
14. XIII зууны эхэн үед Монголын зүүн хойт талд ямар улс оршин байв? /1 оноо/
 А. Сүн улс
 В. Алтан улс
 С. Си-Ся буюу Тангуд улс
 D. Хорезми
 E. Хятан
15. Их Монгол улсын шадар сайд буюу улсын вангаар Чингис хаан анх хэнийг томилсон бэ? /1 оноо/
 А. Мухулай
 В. Шихихутаг
 С. Боорчи
 D. Зэлмэ
 E. Наяа
16. 1206 онд байгуулагдсан Их Монгол улсын хилийн дорно тал нь хаагуур хиллэж байсан бэ? /1 оноо/
 А. Байгаль нуур
 В. Түмэн газрын Цагаан хэрэм
 С. Хянганы нуруу
 D. Алтайн нурууны чанад
 E. Хөвсгөлийн уулс
17. Их Монгол, Монголын эзэнт гүрний үеийн түүхийн хамрах цаг хугацааг нэрлэнэ үү? /1 оноо/
 А. НТӨ 209-НТ XIII зуун
 В. XIII-XIV зуун
 С. XIV-XVII зуун
 D. XVII-XIX зуун
 E. 1911-1919 он
18. Чингис хаан Их Монгол улс байгуулахад гавьяат үйлс бүтээсэн хүмүүсээ дархалсан байдаг. Тэдгээр хүмүүст олгосон эрхэд аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/
 А. Соёрхол газар олгож, эзэмшил нутгаа үе улиран захирах эрхтэй
 В. Дайны ба ав хомрогын олзоо бусадтай хуваалцана.
 С. Алив албан татвараас чөлөөлөгдсөн
 D. Есөн удаагийн осол эндэгдлийг нь хэлтрүүлэх
 E. Хамааралгүй зүйл өгүүлээгүй байна.
19. Монголын Юань гүрэн задарч, Хятад дахь Монголын ноёрхол унахад нөлөөлсөн шалтгаануудыг дурьдахдаа илүүц зүйл өгүүлсэн байна уу? /2 оноо/
 А. Юань улсын эрх баригчдын эрх мэдлийн тэмцэл дотоодын хагарал
 В. Орон нутгийн ноёд түшмэд албан татварын хэмжээг нэмэгдүүлэх зэргээр дураар авирлах ихэссэн
 С. Байгалийн гамшиг тохиолдож хэд хэдэн удаа өлсгөлөн болсон
 D. Хятадад Монголын ноёрхлыг эсэргүүцсэн “Улаан алчууртны” бослого гарсан .
 E. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.
20. Бурхны шашны гутгаар дэлгэрэлт нь Монголын түүхийн аль үед тохиосон бэ? /1 оноо/
 А. Эртний улсуудын үе
 В. Их Монгол улсын үе
 С. Улс төрийн бутралын үе
 D. Манжийн эрхшээлийн үе
 E. Олноо өргөгдсөн Монгол улсын үе
21. Улс төрийн бутралын үеийн зүүн Монголын бүрэлдэхүүнд багтаж байсан баруун гарын түмнүүдийг нэрлэхдээ буруу зүйл оруулсан байна уу? /1 оноо/
 А. Юншээбү
 В. Ордос
 С. Цахар
 D. 12 түмэд
 E. Тийм зүйл өгүүлээгүй байна.
22. Дор дурьдсан үйл явдлуудыг болсон цаг хугацааны дагуу эрэмбэлнэ үү? /2 оноо/
 1. Автай сайн хаан Эрдэнэ зуу хийдийг байгуулсан.
 2. Эсэн тайш Мин улсыг довтолж, эзэн хаан Ин Зуныг олзлов.
 3. Занабазарыг анхдугаар Богдоор өргөмжлөв.
 4. Ойрадын Зая бандида Намхайжамц тод үсэг зохиов.
 А. 1, 2, 3, 4
 В. 3, 2, 1, 4
 С. 2, 1, 3, 4
 D. 4, 1, 3, 2
 E. 2, 1, 4, 3
23. Дараах хаадын хаан ширээнд суусан он цагийг зөв тохируулна уу? /2 оноо/
 А. Эсэн хаан
 В. Батмөнх даян хаан
 С. Түмэн засагт хаан
 D. Лигдэн хаан
 1. 1603 он
 2. 1558 он
 3. 1454 он
 4. 1466 он
 А. a4, b1, c3, d2
 В. a1, b2, c3, d4
 С. a3, b4, c1, d2
 D. a3, b4, c2, d1
 E. a2, b3, c4, d1

24. Дараах өгөгдлүүдэд буруу зүйл өгүүлсэн байна уу? /1 оноо/
 А. 1576 онд Түмэн хаан Төвөдийн улаан малгайтны шашны тэргүүн Гармаа ламыг залж уулзжээ.
 В. 1577 онд Түмэдийн Алтан хан Төвөдийн шарын шашны тэргүүн Содномжамцыг залж уулзжээ.
 С. 1639 онд Ширээ цагаан нуурт Занабазарыг анхдугаар богдоор өргөмжлөв.
 D. 1640 онд Халхад Зая бандида Намхайжамц шарын шашин дэлгэрүүлэв. .
 E. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.
25. Түмэн засагт хааны/1553-1593/улс төрийн үйл ажиллагаанд холбогдох зүйлийг өгүүлэхдээ хамааралгүй зүйл дурьдсан байна уу? /1 оноо/
 А. Монголын улс төрийн нэгдлийг сэргээх оролдлого амжилттай хийсэн.
 В. Баруун, зүүн түмний түмэн тус бүрээс нөлөө бүхий хан ноёдыг оролцуулан, Төв засгийн газар байгуулсан.
 С. Баруун зүүн түмний зөрчлийг улс төрийн аргаар зохицуулах оролдлого хийсэн.
 D. Улсынхаа дотор шашин дэлгэрүүлэх ажлыг төрийн бодлогын хэмжээнд авч үзсэн.
 E. Энд тийм зүйл дурьдаагүй байна.
26. Монголд Буддын шашин гурван удаа дэлгэрсэн. Гурав дахь удаагийн буюу XVI зууны II хагасаас дэлгэрсэн шашин нь эхний хоёр дэлгэрэлтээс юугаараа онцлог байсан бэ? /2 оноо/
 А. Нийтийг хамарч чадаагүй
 В. Бурхны шашны улааны урсгал дэлгэрсэн.
 С. Зөвхөн ордны хэмжээнд язгууртны дунд дэлгэрсэн.
 D. Бурхны шашны шарын урсгал, нийтийг хамран дэлгэрсэн.
 E. Монголын уламжлалт бөөгийн шашны зүгээс дэмжлэг авсан.
27. Дараах бичвэрт цэгийн оронд тохирох өгөгдлийг нөхөн бичнэ үү? /2 оноо/
 XV-XVII зууны үед Хутагтай сэцэн хунтайжийн зохиосон 1. зэрэг хууль цаазын бичиг, Шамба засгийн зохиосон 2. зэрэг түүхийн зохиол, 3. зэрэг түүхэн үйл явдлыг уран зохиолын хэлбэрээр бичсэн зохиолууд бичигджээ.
 а. “Асрагч нэртийн түүх”
 б. “Алтан товч”
 с. “Алтан ханы цааз”
 d. Үйсэн дээр бичигдсэн 18 цаазын хураамж
 e. “Тогоонтөмөр хааны гэмшил”
 А. 1a, 2b, 3c В. 1d, 2b, 3a С. 1b, 2c, 3d D. 1c, 2a, 3e E. 1d, 2e, 3b
28. Батмөнх даян хааныг “Үхэгт хаан” хэмээн нэрлэдэг байсны учир юу вэ? /1 оноо/
 А. Насан бага балчир байх үедээ үхэг тэргэнд сууж явдаг байсан учир
 В. Бусад хаадаас тодруулан онцолж өргөмжилсэн нэр
 С. Мин улсын эрх баригчид доромж маягаар өгсөн нэр
 D. Хаадыг ийнхүү нэрлэдэг уламжлалын дагуу хүлээсэн нэр
 E. Энд энэхүү асуултанд тохирох хариулт байхгүй байна.
29. 1639 онд Ширээ цагаан нуурт Түшээт хан Гомбодоржийн Занабазарыг Халхын шашны анхдугаар богдоор өргөмжилжээ. Энэхүү үйл явдал болсон Ширээ цагаан нуур Монголын өнөөгийн засаг захиргааны хуваариар аль аймгийн нутагт байдаг вэ? /1 оноо/
 А. Архангай В. Төв С. Өвөрхангай D. Хэнтий E. Булган
30. Манжийн Шинэ засгийн бодлогын гол зорилго нь: /2 оноо/
 А. Чин улсын эрх баригчид эсэргүүцэл тэмцлийг намжаах, их гүрнүүдэд өрөө төлөх, ноёрхолоо тогтоон барих
 В. Монгол улсын уламжлалт ёс заншил, соёлыг хөгжүүлэх
 С. Монголыг хятадад уусгахгүй байх
 D. Монголын нүүдлийн иргэншлийг хадгалан хөгжүүлэх
 E. Монголчуудын аж амьдралын түвшинг дээшлүүлэх
31. Дор дурьдсан шинжүүдийн аль нь суман ард гэсэн нийгмийн давхрааг тодорхойлж байна вэ? /1 оноо/
 А. Манжийн захиргааны хэрэгт хүчин зүтгэдэг монголын нийгмийн дээд давхраа
 В. Манжийн төрийн олон зүйлийн хүнд хүчир албанд зүтгэдэг цэрэг эр
 С. Аймаг, хошууныхаа ноёд язгууртнуудын мэдэлд захирагддаг харьяат албат
 D. Хутагт хувилгаад, сүм хийдийн мэдэлд захирагдагсад
 E. Манжийн харуулын алба хаадаг хүмүүс

32. Манжийн төрөөс сүм хийд, лам нарын тоог олшруулах бодлого баримталж байсан боловч хуулинд “... Аливаа лам нар дуртайяа лам болсугай хэмээх нь буй бөгөөс хууль ёсоор Журганд мэдүүлэн бичиг тэмдэг авч лам болго... Хэрэв магад гарахын тэмдэг авсангүй ламыг эргүүлэн хар болгосугай” хэмээсэн байдаг. Энэ баримтанд ямар гаргалгаа хийж болох вэ? /2 оноо/
- A. Лам болох хүн заавал Монгол журганаас зөвшөөрөл авна.
B. Хэрвээ зөвшөөрөл үл авбаас лам болохгүй.
C. Лам болох хүн ГМТЯЗ яаманд мэдүүлнэ.
D. Дээрх бүх хариулт хамаарна.
E. А ба С хариулт хамаарна.
33. Орос, Манж улсын 1727 оны Буурын гэрээгээр хойд хилийг нарийвчлан тогтоож харуулууд байгуулжээ. Харуулуудын гүйцэтгэх үүргийг тодорхойлно уу? /2 оноо/
1. Суман харуул. Жинжлэгээс Ил хүртэл 50 суурь
2. Гэр харуул. Жинжлэгээс Манжуур хүртэл 59 суурь
3. Дотоод харуул
- A. Нутгийн дотор байгуулсан харуулын алба
B. Дан биеэр очиж хаадаг алба
C. Гэр орноороо очиж хаадаг алба
- A. 1B, 2A, 3C
B. 1C, 2A, 3B
C. 1C, 2B, 3A
D. 1B, 2C, 3A
E. 1A, 2C, 3B
34. Манжийг эсэргүүцсэн Монголын ард түмний 1755-1758 оны зэвсэгт тэмцлийн гол ач холбогдол нь юу байсан бэ? /1 оноо/
- A. Монголын ард түмнийг тэмцлийн шинэ сургамжаар баяжуулсан.
B. Баруун Монголчууд эрх чөлөө тусгаар тогтнолоо олж авсан
C. Баруун Монголд биеэ даасан улс байгуулагдсан
D. А ба В хариулт хамаарна
E. В ба С хариулт хамаарна.
35. Манжийн төрийн шинэ засгийн бодлогын хүрээнд соёлын салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг ялган нэрлэнэ үү? /2 оноо/
1. Манжийн төр хятадын худалдаа мөнгө хүүлэгч пүүсүүдийг дэмжих
2. “Монгол үгийн бодрол” сонинг Хятад Монголоор хэвлэн тараав.
3. ГМТЗЯЯ-ны бүтцэд өөрчлөлт оруулан, “Байцаах товчоо” “Найруулах товчоо”-г байгуулав.
4. Уурхай байгуулж ашигт малтмал олборлох, байгалийн баялагыг ашиглах, банк байгуулах зэрэг санал дэвшүүлэн хэрэгжүүлж эхлэв.
5. 1905 онд Их Хүрээнд Цагдан цээрлүүлэх яамыг байгуулсан.
6. Зохиомол өрийн данс нээж, өрийг ихэсгэв.
7. Манж-Хятад хэлний сургуулиуд байгуулав.
8. Монголын цэрэг, харуулын байршил, тоог тодорхойлон гаргасан.
9. Монгол хүүхдэд багаас нь хятад бичиг үсэг, зан заншилд сургах бодлого баримталсан..
- A. 1, 3, 5
B. 2, 7, 9
C. 2, 5, 8
D. 1, 4, 6
E. 3, 4, 7
36. 1900 онд Монголын зүүн хоёр аймгийн нутагт алт олборлохыг эсэргүүцсэн ноёд, тайж, лам нарын эсэргүүцлийн бичигт “... Алтны уурхайг нээн шийтгэвээс үнэхээр монголчуудын аж төрөх арга, жич орон нутагт харштай явдал буй. Иймийн тул олон Монголчууд нэрийг холбож шийтгэхийг зогсоосугай. ...Манай олон аймгууд жич шавь нар цөм алтны уурхайг нээн шийтгэхэд хүсэхгүй” гэсэн байдаг. Энэ баримтанд дор хийсэн дүгнэлтүүдийн аль нь агуулагдаж байна вэ? /2 оноо/
- A. Монголчууд алт олборлохыг эсэргүүцэж байсан.
B. Энэ эсэргүүцэлд нийгмийн янз бүрийн давхраа оролцож байжээ.
C. Алтыг олборлох нь байгаль орчинд харштай гэж үзэж байв.
D. Эдгээр хариултууд тохирно
E. Зөвхөн В ба С хариулт тохирно
37. 1911 оны зун Халхын эрх баригч дээд ноёд, лам нарын нууц зөвлөгөөн хаана болсон бэ? /1 оноо/
- A. Улиастай
B. Ховд
C. Их Хүрээ
D. Хиагт
E. Сан бэйсийн хүрээ
38. 1911 оны Үндэсний хувьсгалын түүхэн ач холбогдол нь: /2 оноо/
- A. Монголчууд манжийн эрхшээлээс гарч, туурга тусгаар улсаа байгуулав.
B. Монгол улсын сэргэн мандалтын эхлэлийг тавилаа.
C. Монголчуудыг хятадчилан уусгах гэсэн хорт бодлогыг таслан зогсоож, үндэс угсааг аврав.
D. Дээрх хариултууд бүгд хамаарна.
E. Зөвхөн В хариулт хамаарна.
39. Улсын Доод хуралд хамаарах зүйлийг дурьдахдаа илүүц зүйлийг өгүүлсэн байна уу? /2 оноо/
- A. Улсын аливаа хэрэгт тустай санаа сэдэж, зөвлөн хэлэлцээд дээд хуралд илтгэнэ.
B. Яамдын дэс түшмэл, эх зохиогч түшмэл, Эрдэнэ шанзудбын яам, дөрвөн аймгийн жанжин, суурин жасааны нэг түшмэл хурлын гишүүнээр томилогдоно.
C. Асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, таслах эрхтэй.
D. Хурлыг Ерөнхий сайдаас томилсон түшмэл удирдана.
E. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.

40. Дор дурьдсан үйл явдлуудаас хэмжээт эрхт хаант Монгол /1921-1924/ улсын үед аль нь хамаарахыг оноон нэрлэнэ үү? /2 оноо/
1. Улсын Дээд, Доод хурал байгуулагдав.
 2. Монгол, ЗОУ-ын хооронд найрамдлын гэрээ байгуулжээ.
 3. “Феодал” агчдын хөрөнгийг хураав.
 4. “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг” хууль гарчээ.
 5. Хувийн худалдааг хориглохоо больж, худалдаачдад тусламж дэмжлэг үзүүлэв.
 6. Жасын кампни гэж нэрлэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэв.
 7. Богд хаан ба Засгийн газрын хооронд “Тангарагийн гэрээ” байгуулав.
 8. Олноор байгуулсан хамтрал, коммуныг татан байгуулав.
- A. 1,4 B. 2,7 C. 3,6 D. 5,8 E. 3,7

41. Сурагч Баярын аав Даржаа одоогийн Говь-Алтай аймгийн нутагт төржээ. Энэ нь уламжлалт засаг захиргааны хуваариар аль аймаг вэ? /1 оноо/
- A. Засагт хан аймаг B. Түшээт хан аймаг C. Сайн ноён хан аймаг
D. Сэцэн хан аймаг E. Дөрвөд Далай ханы аймаг

42. Газрын зурагт Сайн ноён хан аймгийг хэдийн тоогоор дугаарласан байна вэ? /1 оноо/



- A. 1
B. 2
C. 3
D. 4
E. 5

43. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу. /1 оноо/
- 1921.VII.10-нд Ардын засгийн газрын Цэргийн яамны тэргүүн сайдаар-ыг томилжээ.
- A. Да лам Пунцагдорж B. Д.Сүхбаатар C. Д.Бодоо
D. С.Данзан E. Н.Магсаржав

44. 1921-1924 онуудад эдийн засгийн салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг нэрлэнэ үү? /2 оноо/
1. 1921 оны 11 дүгээр сард Судар бичгийн хүрээлэнг байгуулав.
 2. Анхдугаар үндсэн хуулийг баталлаа.
 3. 1921 оны 7 дугаар сард гадаадын пүүсүүдэд төлөх улсын ба иргэдийн өрийг хүчингүй болгов.
 4. 1921 оны 11 дүгээр сард бага сургууль байгуулагдав.
 5. Байнгын засгийн газар байгуулагдлаа.
 6. “Уриа”, “Ардын эрх”, “Ардын цэрэг”, “Ургинская газета”, “Манай үнэн” зэрэг сонин хэвлэгдэн гарав.
 7. Ховд, Зүүн Хараад төрийн өмчийн тариалангийн газар-сангийн аж ахуй байгуулав.
 8. Улс орноо цагаантны цэргээс чөлөөлөв.
 9. Хувийн өмчинд байсан жижиг үйлдвэрүүдийг улсын болгов.
- A. 3, 5, 7 B. 1, 2, 3 C. 2, 4, 6 D. 3, 7, 9 E. 7, 8, 9

45. Дор өгүүлсэн зүйлээс аль нь Догсомын Бодоогийн үзэл бодол вэ? /2 оноо/
- A. “Хэмжээт эрхт хаант засаг бол хуучнаас шинэ байгуулалд шилжих зайлшгүй байх ёстой засаглалын хэлбэр тул тухайн цаг үед нэг хэсэгтээ тохиромжтой.”
- B. “... Бурхны шашнаа хүндэтгэж ард түмнийг амгалан туйл дор хүргүүлэн тэгш журамт баян хүчирхэг улс болохыг гол болгосон хэрэг болой.”
- C. “Юун хэмээвээс ертөнцийн хүн төрөлхтөн бүгдээр найрамдах буюу зөвлөлдөх мэтсийн олон зэрэг дэс байр байх бөгөөд үлгэрлэвээс авирах гишгүүрт нэгээс үүсгэн дэвших ба усанд гүехнээс гүнд орохоор утга адил буй”
- D. “МАН-ын эцсийн зорилт нь эв хамтын ёс мөн бөгөөд нам капитал хөрөнгөтний хөгжлийн шатыг алсгах зорилгод хүрэхээр урагшаа давшин явж байна.”
- E. Аль нь ч биш.

46. 1921 онд байгуулагдсан Судар бичгийн хүрээлэнгийн даргаар хэн ажиллаж байсан бэ? /1 оноо/
- A. Ж.Цэвээн B. Н.Магсар C. Д.Нацагдорж D. С.Жамъян E. Ш.Дамдин

47. А.Амарын үйл ажиллагаа, түүхэнд гүйцэтгэсэн үүргийн талаар илүүц зүйл дор өгүүлсэн байна уу?

/2 оноо/

- A. БНМАУ-ын ерөнхий сайд, УБХ-ын дарга, Гадаад яамны сайдаар ажиллаж байсан
- B. Үндэсний ардчилсан хувьсгалын чиг шугам баримтлаж, “баруунтан” хэмээн буруутгагдаж байсан.
- C. 1945 оны БНМАУ-ын тусгаар тогтнолын төлөөх бүх нийтийн санал хураалтыг зохион байгуулсан.
- D. 1930 онд ШУХүрээлэнгийн даргаар ажиллаж байсан “Монголын товч түүх” бүтээл туурвисан.
- E. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.

48. “Феодал” агчдын хөрөнгийг хураах явцад өрх тус бүр дунджаар 7 төгрөгийн үнэтэй 430 шахам хонь хувьдаа авч үлдэх боломжтой байв. Нэг “хувь” гэдэгт малын үнээр хэдэн төгрөгийн хөрөнгийг тооцож байв?

/2 оноо/

- A. 10 төгрөгийн
- B. 20 төгрөгийн
- C. 30 төгрөгийн
- D. 40 төгрөгийн
- E. 50 төгрөгийн

49. 1945.8.10-нд БНМАУ Японд ямар зорилгоор дайн зарласан бэ?

/2 оноо/

- A. Японы нутаг дэвсгэрийг эзлэн авах
- B. Дэлхийн II дайныг дуусгаж, энх тайвныг тогтоох, тусгаар тогтнолоо хангах.
- C. 1939 онд Халхын голоор довтолсон хариуг авах
- D. А ба В хариулт хамаарна.
- E. В ба С хариулт хамаарна

50. XX зууны монголын урлаг, соёлын зүтгэлтнүүдийн нэрсийг бичсэн гуравдугаар мөрийг ямар шалгуурыг баримтлан үүсгэсэн байна вэ?

/1 оноо/

1. Д.Пүрэвдорж, Р.Чойням, С.Удвал, Б.Явуухулан
2. Ц.Дамдинсүрэн, Б.Ринчин, Ш.Нацагдорж, Б.Ширэндэв
3. Б.Дамдинсүрэн, Р.Мөрдорж, Д.Лувсаншарав, Г.Бирваа
4. О.Цэвэгжав, Г.Одон, Н.Цүлтэм, Л.Гаваа
5. Ж.Жигжид, Б.Сумхүү, Ж.Бунтар, Г.Жигжидсүрэн

- A. Кино урлагийн салбарын төлөөлөл
- B. Монголын уран зургийн салбарын төлөөлөгчид
- C. Монголын зохиолчдын төлөөлөл
- D. Монголын хөгжмийн зохиолчдын төлөөлөл
- E. Монголын шинжлэх ухааны эрдэмтдийн төлөөлөл

51. Доорх төрийн сүлд аль үед хүчин төгөлдөр байсан бэ?

/1 оноо/



- A. 1911-1919 оны үед
- B. 1919-1940 оны үед
- C. 1940-1960 оны үед
- D. 1960-1992 оны үед
- E. 1992 оноос

52. 1990 онд ардчилсан хувьсгал ялж, Монгол орон өөрчлөлт шинэчлэлийн замд орсон.Энэ үйл явдал хэддүгээр жаранд тохиосон бэ?

/1 оноо/

- A. 14 дүгээр жаран
- B. 15 дугаар жаран
- C. 16 дугаар жаран
- D. 17 дугаар жаран
- E. 18 дугаар жаран

53. Хүн амын жилийн дундаж өсөлт:

Он	1960-1970	1970-1980	1980-1990	2000-2010
Өсөлт	2.8	2.9	2.5	1.45

Энэ баримтанд үл хамаарах гаргалгааг хийсэн байна уу?

/2 оноо/

- A. Хамгийн өндөр өсөлт нь 1970-1980 он байлаа
- B. Сүүлийн жилүүдэд хүн амын дундаж өсөлт буурчээ.
- C. 1960-1970 онуудад хүн амын дундаж өсөлт 1980-1990 оныхоос бага байв.
- D. Энэ баримтанд хүн амын дундаж өсөлтийн хамгийн бага үзүүлэлт нь 2000-2010 онд тохиожээ.
- E. Энд тийм зүйл байхгүй байна.

54. 1990 оны Ардчилсан хувьсгалын үр дүнд үл хамаарах зүйл дурьдсан байна уу?

/2 оноо/

- A. Хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг замд орсон.
- B. Хүний эрх, эрх чөлөө үндсэн хуулиар баталгаажин хэрэгжих болсон
- C. ОХУ-ыг аялдан дагалдсан гадаад бодлого явуулах болсон
- D. Олон хэвшил бүхий эдийн засагтай болсон.
- E. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.

55. Өөрчлөлт шинэчлэлийн жилүүдэд улс төрийн салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг нэрлэнэ үү? /2 оноо/.
- 2008 оноос иргэнд газар өмчлүүлэх шийдвэр гарч хэрэгжиж байна.
 - Улс төрийн намуудын тухай хууль батлагдан, олон намын систем тогтов.
 - "Монголын нууц товчоо, төрийн хан хуур, морин хуур, төрийн дуулал, төрийн сүлдээ албан байгууллага, айл өрхүүдэд хүндэтгэлтэйгээр залах шийдвэр гарч хэрэгжиж байна.
 - 2009 онд Монгол улсын төрийн тэргүүнээр Ц.Элбэгдорж сонгогдов
 - Банкны шинэчлэл хийв.
 - Монгол бичгээ сэргээх, хос бичигтэн болох ажил өрнөж байна.
- A. 1, 2, 3 B. 3, 4 C. 5, 6 D. 2, 4 E. 4, 5
56. Өнөөгийн Монгол улсын гадаад бодлогын хоёр дахь чиглэл юу вэ? /2 оноо/
- АНУ, Япон, ХБНГУ зэрэг өндөр хөгжилтэй орнуудтай найрсаг харилцаа тогтоох
 - Хуучин социалист гэгдэж байсан дорнод Европын орнуудтай харилцаагаа сэргээх
 - Уламжлалт харилцаатай хоёр их хөрш ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх
 - Азийн бүс нутагт байр сууриа бататган энэ бүс нутгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох
 - НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудтай хамтран ажиллах

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ, ДАРААЛАЛ СЭРГЭЭХ ДААЛГАВАР

Санамж:

- Даалгаврын хариуг зөв тогтоож харгалзуулах, дараалал сэргээх байдлаар гүйцэтгэнэ үү.
- Зөв хариулт бүр 1 оноотой

- 2.1 .Дараах түүхэн үйл явдлуудын гарсан газар нутгийг өнөөгийн аймаг нутагтай нь тохируулан нэрлэнэ үү? /5 оноо/

- 2000 цэргийн бослого
- Ард Аюушийн тэмцэл
- Саруул гүний хошууны нутаг буюу Толбо нуурын тулалдаан болсон аймаг
- 1932 оны зэвсэгт бослого эхэлсэн аймаг
- 1962 онд Чингис хаанд зориулан босгосон хөшөө



- 2.2 . Манж Чин улс 1728 онд аймгуудын чуулганд нэр өгч чуулж байх газруудыг тогтоожээ. Аймгийн болон чуулганы нэрсийг зөвөөр оноон тохируулна уу? /5 оноо/

- | | |
|-------------------------------------|-------------------------------|
| A. Түшээт хан аймаг | 1. Цэцэрлэгийн чуулган |
| B. Сэцэн хан аймаг | 2. Баруун, зүүн гарын чуулган |
| C. Засагт хан аймаг | 3. Хан уулын чуулган |
| D. Сайн ноён хан аймаг | 4. Хэрлэн барс хотын чуулган |
| E. Далай хан, Үнэн зоригт хан аймаг | 5. Биндэръяа нуурын чуулган |

- 2.3 БНМАУ-ын болон Монгол улсын Засгийн газрын тэргүүнээр ажиллаж байсан хүмүүсийг уг албан тушаалд ажиллаж байсан он цагийн дарааллаар нь/анхныхаас нь эхлэн 1-5 гэж дугаарлана/ эрэмблэнэ үү? /5 оноо/

- П.Жасрай
- Ж.Батмөнх
- Д.Бямбасүрэн
- Д.Содном
- Ю.Цэдэнбал

- 2.4 Цэгийн оронд тохирох утгыг нөхөж бичнэ үү? /5 оноо/

Өмч хувьчлалын эхний шатанд өмчийг А. хувьчлах арга зонхилж байсан ба банкны В. гэсэн хоёр шатлалыг бий болгов. Үнийг чөлөөлөх анхны алхамыг С. хийж, П.Жасрайн Засгийн газар Д. арга хэмжээ авч, Е. чөлөөт үнийн тогтолцоонд шилжжээ.

- Төв болон арилжааны
- М.Энхсайханы Засгийн газар бараа, үйлчилгээний үнийг чөлөөлж
- Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр
- Картын системийг халах, валютын ханшийг чөлөөлөх
- Д.Бямбасүрэнгийн толгойлсон засгийн газар